

3 Тал - Агуулам
Чингэлзэн хөрсний
шилэм үүрэг бичиг 01/26
БАТЛАВ. ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



Л.ГАНБОЛД

ИХ-УУЛ СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ЦЭГИЙН ХОГИЙГ ДАРЖ БУЛАХ, ШИНЭ ЦЭГ
БАЙГУУЛАХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ ХИЙЛГЭХ ЗУРГИЙН ДААЛГАВАР

1. Их-Уул сумын төвөөс 3 км зайд байрлах хог хаягдлын төвлөрсөн цэг нь одоогоор 30 га талбайг бүрхсэн. Урт нь 1000м, өргөн 250-300м. Талбайн төв хэсгээр алаг цоог эрүүл газартай, хогийг хэт тарааж асгасан. Хашаа байхгүй. Газар нь бартаа, налуу байхгүй, тэгш газартай. Үерийн эрсдэл: Сумын хог хаягдлын талбайн 3-ны 1 хувийг үер дайран өнгөрөх эрсдэлтэй байна /Өмнө нь үер орж байгаагүй/.
2. Одоогийн байгаа хур хогтой хэсэгт хийгдэх ажил
 - 2.1. Талбайн зүүн хэсэгт шуудуулсан нүх ухах, нүхний гүн 2-м-ээс багагүй өргөн 3-м –ээс багагүй, урт нь хогын хэмжээнээс хамаарна. Нүхэнд түрсэн хур хогийг дарж, булна.
 - 2.2. Нүхний ухалтаас гарсан шороогоор тухайн дарж булсан хогийг өнгөлж, тэгшилнэ.
 - 2.3. Нүхний гүн 2м, өргөн 5м, урт 5 м-ээс багагүй байна. /хогны хэмжээнээс шалтгаалж, өөрчлөгдөж болно/
 - 2.4. Нүх ухахдаа хөрсний өнгөн хэсгийг хуулж тусд нь тавих ба хогийг дарж булсны дараа өнгөн хөрсөөр өнгөлнө.
 - 2.5. Хогийг түрж булахдаа цахилгаан барааны хаягдал, том овортой машин техникийн хаягдал зэргийг булахгүй. Тусд нь хадгална.
 - 2.6. Түрж булсны дараа талбайг хүний гараар цэвэрлэж, техникийн түрэлтээс үлдсэн жижиг хог хаягдлыг цэвэрлэнэ.
3. Шинээр байгуулах цэгт дараах ажил хийгдэнэ. 2 дугаар зэрэглэлийн ландфиллийн шаардлагад нийцүүлнэ.
 - 3.1. Хогийг түрж гаргасан талбай дээр 100*100м хэмжээтэй, гүн нь 2 м ухаж, хүнхээл хийнэ. Гарсан шороогоор нүхийг тойруулан 2 м өндөртэй далан хийж, өндөрлөнө.
 - 3.2. Даланг нягтруулж, нуралтаас сэргийлэх арга хэмжээ авна.
 - 3.3. Нүхний ёроолыг шаварлаг хөрсөөр тэгшилнэ.
 - 3.4. Шаварлаг хөрсний дээр ус нэвчихгүй гео мембранаар бүрнэ.
 - 3.5. Мембраны дээр хайрган үе 20-30см зузаантай хийнэ.
 - 3.6. Хаягдал ус зайлуулах хоолойнуудыг /d-15см/ хөндлөнгөөр зайтай байршуулж, нэг гол хоолойд цуглуулан далангаас гадагшлуулна.
 - 3.7. Хог хаягдлаас ялгарах хийг гадагшлуулах босоо хоолойг хүнхээлийн 2 газарт байршуула.
 - 3.8. Нүхний нэг талд машин, техник орж гарах налуу замыг хийх, замыг нягтруулж, тэгшилнэ. Бороо цастай үед машин суухааргүй байх.
 - 3.9. Даланг тойруулан мал амьтан орохооргүй тороор хашаагаар хашаална.
 - 3.10. Хашааны гадуур үерийн эрсдэлтэй талд үерийн ус зайлуулах шуудуу далан хийнэ

- 3.11. Хашааны үүдэнд сахиулын 3*3 хэмжээтэй байр байна. байр нь балкаар их биеийг өрж, төмөр дээвэртэй, 2 талдаа цонхтой байна. банзан шалтай, Дулаалгатай байна.
- 3.12. Хашааны хаалга хориглох хаалттай байх ба сахиулын зөвшөөрөлгүйгээр нэвтрэхгүй байхаар зохицуулсан байх.
4. Аюултай, тусгай хаягдлын хэсэг
- 4.1. Үндсэн хүнхээлийн талбайн гадна эмнэлэгийн болон аюултай хог хаягдлыг цуглуулах 2 нүх байна. Уг 2 нүх нь ёроол болон 4 талыг бетондсон 4*3 м хэмжээтэй, гүн нь 2 м нүх байгуулна. Бороо цасны ус орохооргүй дээвэртэй, хүн, мал амьтан орохооргүй цоожтой байна. Хашаатай.
5. Хог хаягдлыг ангилах, шатаах, ангилсан хаягдлыг нөөцлөх хэсэг
- 5.1. Мөн талбайтай залгаад энгийн хог хаягдлыг шатаах зориулалтын технологийн зуух байршуулах талбай байна.
- 5.2. Үндсэн хүнхээлийн хашааны үүд хэсэгт 10*10 хэмжээтэй ангилсан хог хаягдлыг нөөцлөх, ялгах цементлэсэн талбай байна.
- 5.3. Нүхний ухалтаас гарсан бусад шороог талбайн гадна нөөцөлж, овоолох ба ландфиллийн нүхэнд хаясан хогийг тухай бүр дарж, хучихад ашиглана.
- 5.4. Цэгийн талбай бүр тэмдэг, анхааруулгатай байна.
- 5.5. Гал унтраах, галын аюулаас сэргийлэх галын багаж, хэрэгсэл байна.
- 5.6. Цахилгааны шугам татах /220 техникийн нөхцөлөөр/.

БОЛОВСРУУЛСАН:

БОАЖГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.ХАНДАРМАА

ХЯНАСАН:

БОАЖГ-ЫН ДАРГА

Р.ЖАРГАЛСАЙХАН

АЗДТГ-ЫН ХОХБТХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ё.БАТСАЙХАН